



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗРЫН 2022 ОНЫ САНХҮҮГИЙН
НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН
ТАЙЛАН

АУДИТЫН КОД: СНАГ-2023/02/НА-СТА-ТТЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч: Я.Сарансүх
Утас: 261665 Цахим хаяг: saransukhya@audit.gov.mn
Санхүү, нийцлийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Г.Гүнжидмаа
Утас: 261628 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn
Ахлах аудитор: Б.Нарангэрэл
Утас: 261740 Цахим хаяг: narangerelba@audit.gov.mn

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	3
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	4
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	4
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	5
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	9
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	9
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	10
3.4.1 Мөнгөн хөрөнгө	11
3.5.2 Авлага	11
3.5.3 Бараа материал	11
3.5.4 Үндсэн хөрөнгө	12
3.5.5 Өр төлбөр	13
3.5.6 Засгийн газрын хувь оролцоо	14
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	14
3.5.1 Төсвийн төлөвлөлт	14
3.5.2 Төсвийн гүйцэтгэл	14
3.5.3 Нэмэлт төсөв	14
4. АУДИТЫН ТАЙЛАН	16
4.1 Ерөнхий зүйл	16
4.2 Материаллаг байдал	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.5 Өмнөх аудитын зөвлөмжийн хэрэгжилт	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	19
5.1 Харьяа байгууллагууд	19
5.2 Түүвэрт хамрагдсан байгууллага	19
5.3. Албан шаардлага	19
5.4 Зөвлөмж	20
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	22

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БОАЖС	Байгаль орчин, аялал жуулчлалын сайд
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
БОХЗТЛ	Байгаль орчин хэмжил зүйн төв лаборатори
ОББҮХ	Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
УЦУОШТ	Ус, цаг уур, орчны шинжилгээний төв
УЦУОСМХ	Ус, цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн
ЦУОШГ	Цаг уур, орчны шинжилгээний газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ
ГАЗРЫН ДАРГА С.ЭНХТҮВШИН ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2023 03.24 № 01/676
танай _____ -ны № _____ -т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Цаг уур, орчны шинжилгээний газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Цаг уур, орчны шинжилгээний газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар илэрсэн нийт 508.4 сая төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", 15 дугаар зүйлийн 15.4 "Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлангийн тохиолдсон байх, нийцсэн бөгөөд зохистой байх, толилуулга, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант хугацаанд Байгаль орчны төв лабораторийн Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын 2022 оны А/140 тушаалаар Улаанбаатар хотын нийтийн аж ахуйг сайжруулах хоёр дахь төслийн санхүүжилтээр 1,453.7 сая төгрөгийн тоног төхөөрөмж хүлээн авч, хөрөнгөөр бүртгэж, тайлагнасан байна.

Аудитын гол асуудал

Өмнөх оны мөн үеэс тайлант онд цалин хөлс болон нэмэгдэл урамшил, хангамж, бараа материалын зардал, бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс, бараа

үйлчилгээний бусад зардал, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж зэрэг зардал 4,865.0 сая төгрөгөөр өссөн байна.

Бусад асуудлын хэсэг

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд Цаг уур, орчны шинжилгээний газрын харьяа нийслэл болон 21 аймгийн нийт 22 Ус, цаг уур, орчны шинжилгээний төв, Ус, цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн, Байгаль орчин хэмжил зүйн төв лаборатори, Нислэгийн цаг уурын төв, Цаг уур, орчны шинжилгээний газар, нийт 26 төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайланг нэгтгэж, тайлагнасан байна.

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагч 1 зорилтыг хэрэгжүүлэх 32,338.9 сая төгрөгийн 5 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс нийт дүнгээр ажлын гүйцэтгэл 99.1 хувьтай үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ

Я.САРАНСҮХ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	15,238,540.6	14,006,702.7
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	1,596,139.6	193,487.5
33	АВЛАГА	1,307,136.7	718,736.1
35	БАРАА МАТЕРИАЛ	12,335,264.30	13,074,479.0
36	НӨӨЦИЙН БАРАА	-	20,000.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	27,767,847.0	30,054,104.3
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	27,767,847.0	30,054,104.3
39200	Биет хөрөнгө	18,890,684.2	21,015,482.4
39300	Биет бус хөрөнгө	8,877,162.8	9,038,621.9
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	43,006,387.6	44,060,807.0
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,583,516.4	171,892.9
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,583,516.4	171,892.9
41300	Өглөг	1,583,516.4	171,892.9
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	41,422,871.2	43,888,914.1
51	Засгийн газрын хувь оролцоо	41,422,871.2	43,888,914.1
51100	Засгийн газрын оруулсан капитал	25,693,349.1	25,693,349.1
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	25,693,349.1	25,693,349.1
51200	Хуримтлагдсан үр дүн	11,162,449.2	13,825,024.7
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4,567,072.8	4,370,540.3
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	43,006,387.6	44,060,807.0

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

Код	Тайлангийн үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	44,356,329.0	40,240,128.9
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6,492,694.2	4,084,250.0
120	Нийтлэг татварын бус орлого	6,492,694.2	4,084,250.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	37,863,634.8	36,155,878.9
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	36,940,444.9	37,771,007.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	36,632,161.0	37,731,775.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	35,149,292.2	36,047,974.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	22,852,942.9	24,325,859.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,025,107.1	3,065,829.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	896,639.4	991,304.6
2104	Хангамж, бараа материалын зардал	872,920.4	1,068,429.6
2105	Нормативт зардал	105,102.3	27,269.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,570,684.4	378,708.0
2107	Томилолт, зочны зардал	119,300.9	147,047.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,196,651.5	1,104,853.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,509,943.4	4,938,672.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,482,868.7	1,683,801.8
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	308,283.9	39,231.6
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	7,415,884.1	2,469,121.5
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	133,038.8	51,317.1
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)-(V)	7,282,845.3	2,417,804.4

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	32,408,865,100.00	32,157,057,862.28	251,807,237.72	99.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	32,408,865,100.00	32,157,057,862.28	251,807,237.72	99.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	31,138,854,200.00	30,914,736,636.71	224,117,563.29	99.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	24,172,644,400.00	23,987,536,497.27	185,107,902.73	99.2
210101	Үндсэн цалин	17,061,860,100.00	16,999,113,653.56	62,746,446.44	99.6
210102	Нэмэгдэл	5,485,168,300.00	5,421,950,035.42	63,218,264.58	98.8
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,286,441,500.00	1,253,828,160.21	32,613,339.79	97.5
210104	Урамшуулал	339,174,500.00	312,644,648.08	26,529,851.92	92.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,057,511,600.00	3,028,989,331.38	28,522,268.62	99.1
210201	Тэтгэврийн даатгал	2,089,117,900.00	2,073,728,646.52	15,389,253.48	99.3
210202	Тэтгэмжийн даатгал	242,899,200.00	240,963,034.76	1,936,165.24	99.2
210203	ҮОМШӨ-ний даатгал	193,555,300.00	191,891,376.95	1,663,923.05	99.1
210204	Ажилгүйдлийн даатгал	48,376,400.00	47,439,799.09	936,600.91	98.1
210205	Эрүүл мэндийн даатгал	483,562,800.00	474,966,474.06	8,596,325.94	98.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	930,120,300.00	924,124,223.04	5,996,076.96	99.4
210301	Гэрэл, цахилгаан	405,730,300.00	402,181,047.65	3,549,252.35	99.1
210302	Түлш, халаалт	463,758,800.00	462,024,682.03	1,734,117.97	99.6
210303	Цэвэр, бохир ус	45,260,400.00	44,820,136.36	440,263.64	99.0
210304	Байрны түрээс	15,370,800.00	15,098,357.00	272,443.00	98.2
2104	Хангамж, бараа материалын зардал	254,406,900.00	253,563,158.34	843,741.66	99.7
210401	Бичиг хэрэг	23,789,300.00	23,747,700.00	41,600.00	99.8
210402	Тээвэр, шатахуун	102,970,200.00	102,947,253.00	22,947.00	100
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	75,625,200.00	75,021,381.34	603,818.66	99.2
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,386,300.00	3,271,403.00	114,897.00	96.6
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	48,635,900.00	48,575,421.00	60,479.00	99.9
2105	Нормативт зардал	44,098,000.00	43,190,300.00	907,700.00	97.9
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	33,877,500.00	33,877,400.00	100.00	100
210502	Хоол, хүнс	896,000.00	896,000.00	-	100
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	9,324,500.00	8,416,900.00	907,600.00	90.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,979,111,400.00	1,978,274,809.47	836,590.53	100
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,952,505,600.00	1,952,383,385.47	122,214.53	100
210602	Тавилга	-	-	-	-
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,824,500.00	3,807,200.00	17,300.00	99.5
210604	Урсгал засвар	22,781,300.00	22,084,224.00	697,076.00	96.9
2107	Томилолт, зочны зардал	35,133,800.00	34,955,800.00	178,000.00	99.5
210702	Дотоод албан томилолт	35,133,800.00	34,955,800.00	178,000.00	99.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	644,115,200.00	642,661,707.21	1,453,492.79	99.8
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	438,048,800.00	437,965,960.71	82,839.29	100

Цаг уур, орчны шинжилгээний газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	12,311,500.00	11,655,100.00	656,400.00	94.7
210803	Даатгалын үйлчилгээ	18,563,000.00	18,456,860.00	106,140.00	99.4
210804	Тээврийн хэрэгслийн татвар	4,567,500.00	4,519,397.00	48,103.00	98.9
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	1,717,800.00	1,552,301.00	165,499.00	90.4
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	105,738,800.00	105,633,100.00	105,700.00	99.9
210807	Газрын төлбөр	29,917,800.00	29,629,014.00	288,786.00	99.0
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	33,250,000.00	33,249,974.50	25.50	100
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	21,712,600.00	21,440,810.00	271,790.00	98.7
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	12,994,000.00	12,991,850.00	2,150.00	100
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,718,600.00	8,448,960.00	269,640.00	96.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,270,010,900.00	1,242,321,225.57	27,689,674.43	97.8
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,270,010,900.00	1,242,321,225.57	27,689,674.43	97.8
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	12,802,600.00	12,802,227.00	373.00	100
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,248,878,300.00	1,224,718,998.57	24,159,301.43	98.1
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,330,000.00	4,800,000.00	3,530,000.00	57.6
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	32,408,865,100.00	32,157,057,862.28	251,807,237.72	99.2
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	32,338,935,100.00	32,037,855,456.40	301,079,643.60	99.1
310001	Улсын төсвөөс санхүүжих	32,338,935,100.00	32,037,855,456.40	301,079,643.60	99.1
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	69,930,000.00	119,202,405.88	-49,272,405.88	
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	39,730,000.00	56,843,394.00	-17,113,394.00	
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	30,200,000.00	62,359,011.88	-32,159,011.88	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	3,812.00	3,790.00	22.00	99.4
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	26	26	-	
610001	Төсвийн байгууллага	26	26	-	
610002	Төсвөөс гадуур байгууллага	-	-	-	
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	1,893.00	1,882.00	11.00	
620001	Удирдах ажилтан	63	63	-	
620002	Гүйцэтгэх ажилтан	1,744.00	1,742.00	2.00	
620003	Үйлчлэх ажилтан	86	77	9.00	
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	1,893.00	1,882.00	11.00	
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	1778	1659	119	
650005	ШУ-ны салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТУШУ)	29	29	-	
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТУ)	86	194	(108)	

Ца

2.6

2022

Код
II
21
210
2101
21010
210101
210102
210103
210104
2102
21020
210201
210202
210203
210204
210205
2103
21030
210301
210302
210303
210304
2104
21040
210401
210402
210403
210404
210405
210406
2105
210501
210502
210503
2106
210601
210602
210603
210604
2107
210702
2108
210801
210802
210804
210805
210806
210807
210808
2109
210901
210902
213
2132
213204
213209
2133
213303

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	3,363,312,069.11
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	3,269,581,206.11
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	3,063,206,475.34
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	358,280,099.59
210101	Үндсэн цалин	-	345,290,100.59
210102	Нэмэгдэл	-	8,699,999.00
210105	Гэрээт ажлын хөлс	-	4,290,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	43,648,614.46
210201	Тэтгэврийн даатгал	-	43,441,009.46
210202	Тэтгэмжийн даатгал	-	51,983.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	41,638.00
210204	Ажилгүйдлийн даатгал	-	10,437.00
210205	Эрүүл мэндийн даатгал	-	103,547.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	101,201,637.40
210301	Гэрэл, цахилгаан	-	30,542,148.90
210302	Түлш, халаалт	-	65,087,083.50
210303	Цэвэр, бохир ус	-	5,022,405.00
210304	Байрны түрээс	-	550,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	232,417,786.38
210401	Бичиг хэрэг	-	26,523,432.00
210402	Тээвэр, шатахуун	-	137,652,645.50
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	19,369,792.88
210404	Ном, хэвлэл	-	4,000,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	814,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	44,057,416.00
2105	Нормативт зардал	-	20,476,046.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	11,093,546.00
210502	Хоол, хүнс	-	88,200.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	9,294,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	1,421,380,397.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	1,262,912,982.00
210602	Тавилга	-	18,031,040.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	5,856,481.00
210604	Урсгал засвар	-	134,579,894.00
2107	Томилолт, зочны зардал	-	112,514,200.00
210702	Дотоод албан томилолт	-	112,514,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	729,152,133.51
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	716,042,834.51
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	1,006,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	32,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	-	33,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	253,000.00
210807	Газрын төлбөр	-	11,484,834.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	300,265.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	44,135,561.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	41,910,631.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	2,224,930.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	206,374,730.77
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	114,698,544.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	62,894,685.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	51,803,859.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	91,676,186.77
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	-	14,149.00

Цаг уур, орчны шинжилгээний газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	-	3,500,000.00
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	88,162,037.77
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	93,730,863.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	93,730,863.00
221001	Их засвар	-	93,730,863.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	3,373,674,209.11
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	3,373,674,209.11
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	1,280,614,729.62
131103	ЗГНХ, ЗДНХ хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	197,857,173.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	1,506,912,907.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	388,289,399.49
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	-	10,362,140.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	1,596,139,627.19
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	193,487,542.79

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Цаг уур, орчны шинжилгээний газар нь эрхэм зорилгоо “Ус, цаг агаар, байгаль орчны төлөв байдалд байнгын хяналт шинжилгээ хийж, бодит болон урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээллээр нийгмийн хэрэгцээг шуурхай хангах, байгалийн болзошгүй гамшгийн эрсдэлээс сэрэмжлүүлэхэд оршино” гэж тодорхойлсон байна.

Эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэхээр Алсын хараа-2050 хөгжлийн хөтөлбөрт тулгуурлан “Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө”-ний хүрээнд Монгол орны уур амьсгал, усны нөөц, байгаль, цаг агаарын тааламжтай нөхцөлийг эдийн засгийн хөгжлийг эрчимжүүлэхэд бүрэн ашиглах, байгаль, цаг агаарын болзошгүй аюул гамшиг, орчны ноцтой бохирдлоос урьдчилан сэргийлж, нийгэм, эдийн засагт учруулах хохирлыг багасгаж, улс орны дунд хугацааны тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн дор дурдсан зорилтыг дэвшүүлсэн байна. Үүнд:

- Ус цаг уур, байгаль орчны хяналт шинжилгээний улсын сүлжээний хэвийн үйл ажиллагаа, хэмжлийн нэгдмэл байдлыг хангах, техник технологийн шинэчлэл хийх
- Ус, цаг уур, орчны мэдээллийн төрийн архивыг эрхлэх, цаасан болон цахим архив бүрдүүлэх, баяжуулах;
- Цаг агаарт зориудаар нөлөөлөх арга технологийг боловсронгуй болгох;
- Мэдээлэл солилцоо, дамжуулалтын чанарыг сайжруулах, дотоод сүлжээ, интернэтийн хурдыг нэмэгдүүлэх;
- Ус, цаг агаар, орчны бодит болон урьдчилсан мэдээ, мэдээллээр нийгмийн хэрэгцээг тасралтгүй шуурхай хангах;
- Ус, цаг агаар, уур амьсгалын гаралтай /ган, зуд/ аюултай болон гамшигт үзэгдлээс эртнээс сэрэмжлүүлэх;
- Супер компьютерын технологид суурилсан ус, цаг агаар, орчны загварчлалын системийг өргөжүүлэн, хөгжүүлэх;
- Уур амьсгалын өөрчлөлтийн Монгол орны экосистемд үзүүлэх нөлөөллийн үнэлгээг нарийвчлан хийх;
- Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийг боловсронгуй болгох, байгууллагын бүтцийг шинэчлэн зохион байгуулах, эрэлт хэрэгцээнд үндэслэн мэргэжлийн хүний нөөцийг бүрдүүлэх, салбарын гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх.

Цаг уур, орчны шинжилгээний газар нь:

- Монгол Улсын хэмжээнд ус цаг уур, байгаль орчны төлөв байдал, чанарын хяналт шинжилгээг зохион байгуулж, хэрэглэгчийг мэдээллээр шуурхай хангах, ус, цаг агаарын аюултай үзэгдлийн улмаас үүсэж болзошгүй гамшгийн эрсдэлээс эртнээс сэрэмжлүүлэх;
- Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний улсын сүлжээг нэгдсэн удирдлага, нэгдмэл арга зүйгээр хангах, өргөжүүлэх, чадавхыг бэхжүүлэх;
- Ус цаг уур, байгаль орчны чанарын хяналт шинжилгээний улсын сүлжээний үйл ажиллагааг тасралтгүй явуулж, мэдээлэл цуглуулах, түүнийг хэрэглэгчдэд шуурхай хүргэх техникийн найдвартай ажиллагааг хангах, техник технологийн байнгын шинэчлэл хийх;
- Ус, цаг уур, байгаль орчны архив, мэдээллийн нэгдсэн сан үүсгэх ажлыг удирдан зохион байгуулах, хэрэглэгчдийг мэдээллээр үйлчлэх үйл ажиллагааны чиглэлтэй.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Ус цаг уур орчны хяналт шинжилгээний салбарт өнөөгийн байдлаар Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай, Агаарын тухай, Байгалийн ургамлын тухай, Гамшгаас хамгаалах тухай, Усны тухай зэрэг гол хуулиудаас гадна салбарын хамаарал бүхий 12 хууль, УИХ-ын болон Засгийн газрын тогтоолоор 9 үндэсний хөтөлбөр, нийт 11 үзэл баримтлал, үндсэн чиглэл, төлөвлөгөөг баталсан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх дараах хууль тогтоомж, бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна.Үүнд:

- Төрийн хэмнэлтийн тухай хууль;
- Сангийн сайдын “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах зааврыг шинэчлэн батлах тухай” 2021 оны 190 дүгээр тушаал;
- Монгол Улсын Засгийн газрын 2022 оны “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох” 107 дугаар тогтоол;
- Сангийн сайдын 2022 оны “Албан томилолтын зардлын тариф шинэчлэн батлах тухай” 120 дугаар тушаал;

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил хэрэгжүүлэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна. Аудитын явцад дотоод аудитын жилийн ажлын төлөвлөгөө, тайлан ирүүлээгүй болно.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлсөн байна.

Цаг уур, орчны шинжилгээний салбарт мөрдөх 2020 онд боловсруулсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт холбогдох хууль тогтоомжийн өөрчлөлтийг тусган шинэчлээгүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Цаг уур, орчны шинжилгээний газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,054.4 сая төгрөгөөр буюу 2.5 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
1	2	3	4=3-2
Мөнгөн хөрөнгө	1,596,139.6	193,487.5	(1,402,652.1)
Авлага	1,307,136.7	718,736.1	(588,400.6)
Бараа материал	12,335,264.3	13,074,479.1	739,214.8
Нөөцийн бараа	-	20,000.0	20,000.0
Үндсэн хөрөнгө	27,767,847.0	30,054,104.3	2,286,257.3
НИЙТ ХӨРӨНГӨ	43,006,387.6	44,060,807.0	1,054,419.4
Өглөг	1,583,516.4	171,892.9	(1,411,623.5)
Засгийн газрын хувь оролцоо	41,422,871.2	43,888,914.1	2,466,042.9
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ	43,006,387.6	44,060,807.0	1,054,419.4
ӨМЧИЙН ДҮН			

Эх сурвалж: Цаг уур, орчны шинжилгээний газар 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 1,402.7 сая, авлага дансны үлдэгдэл 588.4 сая, өглөг дансны үлдэгдэл 1,411.6 сая төгрөгөөр тус тус буурч, бараа материал дансны үлдэгдэл 739.2 сая,

үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,286.3 сая, Засгийн газрын хувь оролцоо 2,466.0 сая төгрөгөөр тус тус өссөн байна.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт(+), Бууралт (-)
Төрийн сангийн харилцах	1,581,978.7	168,964.5	(1,413,014.2)
Нэмэлт санхүүжилтийн харилцах	14,160.9	24,523.0	10,362.1
Дүн	1,596,139.6	193,487.5	(1,402,652.1)

Эх сурвалж: Цаг уур, орчны шинжилгээний газар 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдлийн 169.0 сая төгрөг төрийн сангийн харилцах дансанд, нэмэлт санхүүжилтийн дансанд 24.5 сая төгрөг байршиж байна. Үүнд: Говьсүмбэр аймгийн УЦУОШТ 2.9 сая, Дундговь аймгийн УЦУОШТ 21.5 сая төгрөгийн ахмадын сангийн дансны үлдэгдэл, Цаг уур, орчны шинжилгээний газарт улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтээр хиймэл дагуулын цамхгийн байр барих ажлын гүйцэтгэлийн барьцаа 169.0 сая төгрөг байна.

Аудитын илрүүлэлт:

Өмнөговь аймгийн УЦУОШТ анхан шатны баримтын иж бүрдэл хангаагүй 0.2 сая төгрөгийн ажил гүйлгээ хийсэн;

Дорноговь аймгийн УЦУОШТ 11 харилцагчаас 2.2 сая төгрөгийн худалдан авалтад и-баримт байхгүй..

3.5.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 718.7 сая төгрөг болж, өмнөх оноос 588.4 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагсадтай холбогдсон авлага	394.0	-	(394.0)
Төлбөртэй үйлчилгээний авлага	240.0	-	(240.0)
Татаас, санхүүжилтийн авлага	45,876.6	67,602.0	21,725.4
Байгууллагаас авах авлага	1,246,826.1	651,134.1	(595,692.0)
Хувь хүмүүсээс авах авлага	13,800.0	14,422.9	622.9
Дүн	1,307,136.7	718,736.1	(588,400.6)

Эх сурвалж: Цаг уур, орчны шинжилгээний газар 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлага дансны 718.7 сая төгрөг үлдэгдэлд ЦУОШГ-ын татаас санхүүжилтийн авлага 18.1 сая, Ус, цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэнгийн татаас санхүүжилтийн авлага 67.6 сая төгрөг, 2021 онд БНХАУ-аас цаг агаарт зориудаар нөлөөлөх сум пуужингийн үнэ, Гаалийн ерөнхий газарт шилжүүлсэн гааль болон НӨАТ төлсөн нийт 615.7 сая төгрөг, Баянхонгор, Говьсүмбэр, Дундговь аймгуудын УЦУОШТ-ийн ХХОАТ-ын авлага 0.3 сая төгрөг, Дорнод УЦУОШТ-ийн 17.0 сая төгрөгийн цалингийн тооцооны авлага тус тус байна.

Авлага дансны үлдэгдэл 588.4 сая төгрөгийн бууралтад ЦУОШГ-ын чийг температурын мэдрүүлийн үнэ 541.4 сая, гаалийн татвар 87.4 сая төгрөгийн авлагыг барагдуулсан нь голлон нөлөөлсөн байна.

3.5.3 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 13,094.5 сая төгрөг болж, өмнөх оноос 759.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	5,875,222.9	6,298,229.0	423,006.1
Тусгай зориулалттай материал	5,861,620.0	6,260,281.8	398,661.8
Эм боох материал	13,602.9	37,947.2	24,344.3
Дуусаагүй үйлдвэрлэл	4,221,206.1	4,674,396.4	453,190.3
Бэлэн бүтээгдэхүүн	2,313.0	460.0	(853.0)
Хангамжийн материал	2,208,816.4	2,040,138.6	(168,677.8)
Бичиг хэргийн материал	100,113.7	104,353.8	4,240.1
Аж ахуйн материал	513,026.9	484,046.0	(28,980.9)
Сэлбэг хэрэгсэл	966,191.9	798,208.0	(167,983.9)
Түлш, шатах тослох материал	28,960.7	33,978.1	5,017.4
Барилгын засварын материал	21,807.4	17,246.4	4,561.4
Бусад хангамжийн материал	578,715.9	602,306.3	23,590.4
Мал амьтад	27,705.9	61,255.0	33,255.0
Нөөцийн бараа	-	20,000.0	20,000.0
Дүн	12,335,264.3	13,094,479.0	759,214.7

Эх сурвалж: Цаг уур, орчны шинжилгээний газар 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд 4,734.6 сая төгрөгийн шинжилгээний ажлын бараа материал, багаж, тоног төхөөрөмж худалдан авч, 2,324.7 сая төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй хүлээн авч, харьяа байгууллагад 3,550.4 сая төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй шилжүүлэн, 2,338.7 сая төгрөгийн бараа материалыг зарцуулж, байгууллагын Өмч хамгаалах комиссын дүгнэлт болон газрын даргын шийдвэрээр 401.6 сая төгрөгийн бараа материалыг акталж, 29,390.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг дансанд шилжүүлэн бүртгэсэн байна.

Бараа материалын үлдэгдэлд ЦУОШГ 5,991.6 сая төгрөг, Төв аймгийн УЦУОШГ 1,045.6 сая төгрөг, Булган аймгийн УЦУОШГ 1,071.0 сая төгрөг зэрэг нийт 26 байгууллага үлдэгдэлтэй байна.

Аудитын илрүүлэлт

Говьсүмбэр аймгийн УЦУОШТ-Жолоочийн тооцооны хуудсанд нийт 4295 км-ын зарцуулалт, байгууллагын даргын явсан ажлын автомашиныг ямар албан ажилд ашигласан талаарх гүйцэтгэл тодорхойгүй,

Дундговь аймгийн УЦУОШТ-Ажилтнуудтай эд хариуцагчийн бүрэн хариуцлагын гэрээг байгуулаагүй,

Дорнод аймгийн УЦУОШТ-Бараа материалын дансанд бүртгэлтэй 292.6 сая төгрөгийн бараа материалд тооллого хийгээгүй,

Орхон аймгийн УЦУОШТ-Лабораторийн бодис урвалжийг бараа материалын дансанд орлогодож авдаг боловч зарцуулалтын тооцоогүй. Өөрийн орлогын дүгнэлт шинжилгээ, тодорхойлолтод ямар бодис урвалж хэчнээн хэмжээтэй ордог нь тодорхойгүй жилийн эцсээрх үлдэгдэл тоолдоггүй, бодисын тооцоололгүй, өөрийн орлогын дүгнэлт, тодорхойлолтод хяналт тавигддаггүй,

Өмнөговь аймгийн УЦУОШТ-Бараа материалын 51 ажил гүйлгээгээр хийсэн 1.3 сая төгрөгийн баримт тамга тэмдгээр баталгаажаагүй,

3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 30,054.1 сая төгрөг болж, өмнөх оноос 2,286.3 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/ мянган төгрөгөөр /

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	18,890,684.2	21,015,482.4	2,124,798.2
Барилга, байгууламж, орон сууц	9,227,717.0	9,680,161.0	452,444.0
Авто-тээврийн хэрэгсэл	1,290,975.4	1,682,762.4	391,787.0
Машин тоног төхөөрөмж(компьютер)	7,901,666.6	9,171,635.3	1,269,968.7
Тавилга, аж ахуйн эд хогшил	336,428.2	301,323.6	(35,104.6)

Бусад үндсэн хөрөнгө	130,643.4	176,346.4	45,703.0
Ном	3,253.6	3,253.6	0.0
Биет бус хөрөнгө	8,877,162.8	9,038,621.9	161,459.1
Программ хангамж	211,868.8	236,626.0	24,757.2
Бусад биет бус хөрөнгө	8,665,294.0	8,801,995.9	136,701.9
Дүн	27,767,847.0	30,054,104.3	2,286,257.3

Эх сурвалж: Цаг уур, орчны шинжилгээний газар 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант хугацаанд 574.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч, 1,586.3 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн авч, хандиваар хүлээн авсан 361.7 сая төгрөг, дахин үнэлгээний нэмэгдэл 87.8 сая төгрөг, бусад 3,398.7 сая төгрөгийн хөрөнгөөр тус тус нэмэгдэж, 56.3 сая төгрөгийн хөрөнгийг балансаас балансад шилжүүлж, 606.3 сая төгрөгийн хөрөнгийг акталж, бусад 2,391.8 сая төгрөгийн хөрөнгийг данснаас хассан байна.

Үндсэн хөрөнгө дансны 2,286.3 сая төгрөгийн өсөлтөд Байгаль орчны төв лабораторийн ЦУОШГ-ын даргын 2022 оны А/140 тушаалаар Улаанбаатар хотын нийтийн аж ахуйг сайжруулах хоёр дахь төслийн санхүүжилтээр 1,453.7 сая төгрөгийн тоног төхөөрөмж, БОАЖЯ-ны 2022 оны 02/79 тоот шийдвэрээр 673.7 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 2021 оны А/428 дугаар тушаалаар 41.1 сая төгрөгийн тээврийн хэрэгсэл, БОАЖС-ын 2022 оны 243 дугаар тушаалаар 28.5 сая төгрөгийн хөрөнгийг хүлээн авсан, Цаг уур, орчны шинжилгээний газар нь 217.2 сая төгрөгийн хөрөнгө худалдан авч, харьяа 12 байгууллагын их засвар 129.1 сая төгрөгийн сайжруулалтыг капиталжуулж бүртгэсэн, Өвөрхангай аймгийн УЦУОШТ нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 405.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий өртөөний барилга хүлээн авч бүртгэсэн, ЦУОШГ, ОББҮХ-оос нийт 138.1 сая төгрөгийн тээврийн хэрэгсэл тоног төхөөрөмж хүлээн авсан зэрэг нь голлон нөлөөлсөн байна.

Аудитын илрүүлэлт:

Баянхонгор аймгийн УЦУОШТ-Байгууллагын хөрөнгөд бүртгэлтэй автомашинуудад 6.8 сая төгрөгийн сэлбэг хэрэгсэл худалдан авч засвар үйлчилгээ хийхдээ Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 86 дугаар тогтоолоор баталсан "Өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны нийтлэг журам"-ын 3.13 дахь заалтыг хэрэгжүүлээгүй,

Ховд аймгийн УЦУОШТ-Байгууллагын үндсэн хөрөнгийн бүртгэлд 19 нэр төрлийн 3.6 сая төгрөгийн бараа материал, элэгдлээрээ өртгөө нөхсөн 248 нэр төрлийн хөрөнгө, бараа материалын дансанд үндсэн хөрөнгийн шинжтэй 13 нэр төрлийн 75.9 сая төгрөгийн хөрөнгүүд тус тус бүртгэлтэй,

УЦУОСМХ-Хөрөнгийг бүртгэлд тусгаагүй, тайлант оны 10, 11, 12 дугаар сарын биет бус хөрөнгийн элэгдэл, ашиглалтад авсан үндсэн хөрөнгийн 2.7 сая төгрөгийн элэгдлийг тооцоогүй,

БОХЗТЛ-Байгууллагын эзэмшил газарт бариулсан ажилчдын орон сууцны газрын төлбөрт 2016-2022 онуудад төсвөөс 6.6 сая төгрөг төлсөн.

3.5.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 171.9 сая төгрөг болж, өмнөх оноос 1,411.6 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/ мянган төгрөгөөр /

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажилчидтай холбогдсон өглөг	1,529.7	293.0	(1,236.7)
Байгууллагад төлөх өглөг	1,581,986.7	168,964.5	(1,413,022.2)
Хувь хүмүүст өгөх өглөг	-	2,635.3	2,635.3
Дүн	1,583,516.4	171,892.8	(1,411,623.6)

Эх сурвалж: Цаг уур, орчны шинжилгээний газар 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэл 1,411.6 сая төгрөгөөр буурсан нь ажиллагсадтай холбоотой өглөг 0.3 сая төгрөг, байгууллагад төлөх өглөг 1,413.0 сая төгрөг, хувь хүнд өгөх өглөг 2.6 сая төгрөгийг барагдуулснаас тус тус шалтгаалжээ.

Өглөгийн үлдэгдэлд Баянхонгор аймгийн УЦУОШТ ажилчидтай холбоотой тооцооны 0.3

сая төгрөг, ХАОАТ-ын тооцоотой холбоотой өглөг Говьсүмбэр аймгийн УЦУОШТ, Дорнод аймгийн УЦУОШТ 2.7 сая төгрөг, ЦУОШГ-ын хиймэл дагуулын цамхгийн байрны чанарын баталгааны 5 хувь болох 168.9 сая төгрөгийн өр төлбөр бүртгэлтэй байна.

3.5.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 43,888.9 сая төгрөг болж, өмнөх оноос 2,466.0 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо

Хүснэгт 3. Засгийн газрын хувь оролцоо			/мянган төгрөгөөр/
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	25,693,349.1	25,693,349.1	-
Хуримтлагдсан үр дүн	11,162,449.2	13,825,024.7	2,662,575.5
Өмнөх үеийн үр дүн	3,879,603.9	11,407,220.2	7,527,616.3
Тайлант үеийн үр дүн	7,282,845.3	2,417,804.4	(4,865,040.9)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4,567,072.8	4,370,540.3	196,532.5
Дүн	41,422,871.2	43,888,914.1	2,466,042.9

Эх сурвалж: Цаг уур, орчны шинжилгээний газар 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2022 оны төсвийн төсөлд урсгал үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 38,731.1 сая төгрөг, үйл ажиллагааны орлогоос 69.9 сая төгрөг, нийт зарлагыг 38,801.0 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн анхны саналыг 7,311.7 сая төгрөгөөр бууруулан 31,489.3 сая, төсвийн тодотголоор 769.2 сая төгрөгөөр бууруулж 30,720.1 сая, төсөвт дахин тодотгол хийж 1,688.8 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 32,408.9 сая төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 32,339.0 сая төгрөгийг улсын төсвөөс, 69.9 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогыг ЦУОШГ цаг агаарын мэдээний үйлчилгээний орлого 23.7 сая, Байгаль орчин, хэмжил зүйн төв лаборатори шинжилгээний орлого 14.2 сая, бусад аймгуудын УЦУОШТ цаг уурын мэдээний орлого 11.4 сая төгрөгөөр баталсан төсвөөс тус тус давж орсноос шалтгаалжээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 32,338.9 сая төгрөгөөр баталснаас 32,037.9 сая төгрөгийн гүйцэтгэлтэй ажиллаж, 301.0 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл түүний хэтрэлт, хэмнэлтийн орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2 “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хандив тусламжаар 7 байгууллага, аж ахуйн нэгжээс 1,280.6 сая төгрөг, Засгийн газрын нөөц сангаас 197.8 сая төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 1,506.9 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 388.3 сая төгрөг, нийт 3,373.6 сая төгрөгийн орлогыг бүрдүүлэн 3,269.6 сая төгрөгийг зарцуулж, 79.5 сая төгрөгийг улс орон нутгийн орлогын дансанд татан төвлөрүүлж, 24.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Цаг уур, орчны шинжилгээний газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторов дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн болон дотоод аудитын үйл ажиллагааг сайжруулах, холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Санхүү-нийцлийн аудитын газрын ахлах аудитор Б.Нарангэрэл гүйцэтгэж, үе шатны хяналтыг аудитын менежер Г.Гүнжидмаа, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Монгол Улсын Ерөнхий аудиторов орлогч Я.Сарансүх нар тус тус хэрэгжүүлсэн.

Цаг уур, орчны шинжилгээний газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2023 оны 3 дугаар сарын 03-ны өдрийн 01/111 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны нийт зардал 37,822.3 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 378.2 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллага нь батлагдсан төсвийг хэтрүүлэлгүй, сул орон тоог хадгалах, дотоод цахим сүлжээ ашиглах зэрэг зардлыг хэмнэх арга хэмжээ авч ажилласан байна.

Энэ хуулийн хүрээнд 9 сул орон тоог хадгалснаар 26.5 сая төгрөгийн цалинтай холбоотой зардал, дотоод цахим шуудан ашигласантай холбоотой 0.5 сая төгрөгийн шуудан холбооны зардал, нийт 27.0 сая төгрөгийн бодит хэмнэлтийг бий болгожээ.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн аудитын асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторов дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээллийг бүрэн байршуулсан байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 223.7 сая төгрөгийн 11 зөрчил илэрснээс 7.5 сая төгрөгийн 3 зөрчилд албан шаардлага, 216.2 сая төгрөгийн 7 зөрчилд зөвлөмж өгсөн байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Цаг уур, орчны шинжилгээний газрын харьяа байгууллагуудад нийцлийн аудитын нийт 51.1 сая төгрөгийн 8 зөрчил илэрснээс, 0.3 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 1,434.1 сая төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага, 49.4 сая төгрөгийн зөрчилд 5 зөвлөмж хүргүүлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл болон худалдан авах ажиллагаа зэрэг нийцлийн аудитын асуудал нь Шилэн дансны тухай болон бусад хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

Аудитын илрүүлэлт:

- Худалдан авах ажиллагаа болон бусад хууль тогтоомжтой холбоотой 51.1 сая төгрөгийн зөрчил илэрсэн /ЦУОШГ 49.4 сая төгрөг, Говьсүмбэр аймгийн УЦУОГТ 1.4 сая, Баянхонгор аймгийн УЦУОГТ 0.2 сая төгрөг/

- Шилэн дансны тухай хуулийг бүрэн хэрэгжүүлээгүй нийт 223.7 сая төгрөгийн зөрчил илэрсэн /Говьсүмбэр аймгийн УЦУОГТ 7.5 сая төгрөг, Өмнөговь аймгийн УЦУОГТ 19.6 сая төгрөг, Хөвсгөл аймгийн УЦУОГТ 196.6 сая төгрөг/

1. Албан шаардлага

1.1. Худалдан авах ажиллагааг харьцуулалтын аргаар 4 удаа зохион байгуулахдаа шалгаруулалт амжилтгүй болсон шалтгааныг судалж, тогтоогоогүй, оролцогчийн ирүүлсэн саналд барааны гарал үүсэл, өртгийн тооцоо байгаагүй, техникийн тодорхойлолт, тавигдах шаардлагыг өөрчлөхөд бараа материалын тоо хэмжээ, хэмжих нэгжийг харьцуулан тооцолгүй шууд гэрээ байгуулж, худалдан авалт хийсэн.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.4 "Бүх тендерээс татгалзсан тохиолдолд захиалагч дараах шийдвэрийн аль нэгийг гаргана", 30.4.1 "тендер шалгаруулалт амжилтгүй болсон шалтгааныг судалж, тендерийн баримт бичгийн агуулгад шаардлагатай өөрчлөлт оруулж, нээлттэй тендер шалгаруулалт явуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Тендерийн баримт бичгийг холбогдох хууль, журам зааврын дагуу болон байгууллагын хэрэгцээ шаардлагад нийцүүлэн чанартай боловсруулан, худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг үр дүнтэй зохион байгуулах тухай албан шаардлага өгөв.

2. Зөвлөмж

2.1. Илрүүлэлт:

Тайлант хугацаанд 7.7 сая төгрөгийн худалдан авалтыг анхан шатны баримт болох цахим төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 347 дугаар тушаалаар "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягыг нөхөх заавар", "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 5 "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Худалдан авалтын ажил гүйлгээг тухай бүр цахим төлбөрийн баримтаар баталгаажуулж, хяналт хэрэгжүүлж ажиллах.

4.5 Өмнөх аудитын зөвлөмжийн хэрэгжилт

Хүснэгт 12. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт			/мянган төгрөгөөр/		
Үзүүлэлт	Өмнөх аудитаар		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	3,036.6	1	3.0	100
Албан шаардлага	24	804,432.1	24	804,432.1	100
Зөвлөмж	31	74,192.6	31	74,192.6	100
Нийт дүн	56	881,661.3	56	881,661.3	100

Өмнөх аудитаар дотоод аудитын үйл ажиллагааг сайжруулах, илэрсэн алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгсөн байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитын цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан дараах асуудлуудыг нарийвчлан шалгах боломжгүй байсан тул дараагийн аудитаар нягтлан үзэх нь зүйтэй гэж үзлээ. Үүнд.

1. Бараа материалын тодруулга тайлан дахь дуусаагүй үйлдвэрлэлийн дансанд байгаа он дамжсан их хэмжээний буюу 4,221.2 сая төгрөгийн үлдэгдэл,
2. ЦУОШГ-ын санхүүгийн байдлын тайлан болон тодруулга тайлангууд дахь эх үүсвэр, зарцуулалт, бүртгэл нь тодорхой бус бараа материал, үндсэн хөрөнгүүд
3. Санхүүгийн үр дүнгийн тайланд тусгасан хөрөнгийн зардлын шалтгаан, үр дагавар,
4. Төсвийн байгууллагын хувьд гаднын байгууллагуудаас хүлээн авсан хандив, дэмжлэг, үнэ төлбөргүй орлого

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар илэрсэн залруулагдаагүй нийт 508.4 сая төгрөгийн 40 зөрчлөөс 15.1 сая төгрөгийн 10 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 315.7 сая төгрөгийн зөрчлийг арилгах 10 албан шаардлага хүргүүлж, 177.6 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 21 зөвлөмжийг хүргүүлсэн.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 26 төсвийн байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэснээс 23 байгууллагад дүгнэлт гаргаж, 3 байгууллагыг аудитын түүвэрт хамруулсан.

5.1 Харьяа байгууллагууд

Аудитад хамрагдсан харьяа 22 байгууллагуудын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” дүгнэлт, Дорнод аймгийн УЦУОШГ-т “Хязгаарлалттай” дүгнэлт тус тус өгсөн байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 2,032.2 сая төгрөгийн 42 алдаа илэрснээс 1,997.8 сая төгрөгийн 37 алдааг аудитын явцад залруулж, 4.4 сая төгрөгийн алдааг давтан гаргахгүй байх 4 зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Залруулагдаагүй нийт 420.5 сая төгрөгийн 36 зөрчлийн 15.1 сая төгрөгийн 10 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 315.7 сая төгрөгийн зөрчлийг арилгах 8 албан шаардлага хүргүүлж, 89.6 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 18 зөвлөмжийг хүргүүлсэн байна.

5.2 Түүвэрт хамрагдсан байгууллага

Аудитаар нийт 87.9 сая төгрөгийн 4 зөрчил илэрснээс 2 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 87.9 сая төгрөгийн алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх тухай 3 зөвлөмж өгсөн.

5.3. Албан шаардлага

1. Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналт сул байгаагаас харьяа байгууллагуудын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар нийт 508.4 сая төгрөгийн зөрчил илэрч, үүний 15.1 сая төгрөгийн 10 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 315.7 сая төгрөгийн 10 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 177.6 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 20 зөвлөмж өгсөн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 “Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 14 дүгээр зүйлийн 14.2.3 “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах” 35 дугаар зүйлийн 35.2 “Төсвийн байгууллага нь төвлөрүүлсэн төсвийн орлого болон өөрийн үйл ажиллагааны орлогыг Төрийн сангийн нэгдсэн дансанд саадгүй байршуулна” заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн сахилга батыг сайжруулж, дотоод хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлэх, аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх албан шаардлага өгөв.

2. ЦУОШГ-ын 2022 оны санхүүгийн тайлангийн төсвийн гүйцэтгэлийн тайланд гэрэл цахилгаан, түлш халаалт, багаж техникийн зардалд тооцсон 97.9 сая төгрөгийг төсөвт зохицуулалт хийж хуваарилалгүй, Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын 2022 оны А/238 тушаалаар харьяа 17 байгууллагын өр төлбөрийг барагдуулахаар шилжүүлсэн. Санхүүжилт авсан 14 байгууллага нь нийт 73.5 сая төгрөгийг тухайн зардлын ангиллын зориулалтаар зарцуулаагүй байна. Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.2 “төсвийн захирагч нь төсвийн асуудлаа өөрийн харьяалагдах дээд шатны төсвийн захирагчаар дамжуулан шийдвэрлүүлдэг байх. 42 дугаар зүйлийн”, 42.3 “Төсвийн шууд захирагчийн төсөвтөө зохицуулалт хийх асуудлыг дараах байдлаар шийдвэрлэнэ”, 42.3.2 “төсвийн төвлөрүүлэн захирагч нь саналаа харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх”, 42.7 “Төсөвт зохицуулалт хийхдээ хөрөнгийн болон урсгал зардлыг хооронд нь шилжүүлэх, төсөвт тусгагдаагүй шинэ хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглоно” заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Харьяа байгууллагуудын төсвийн хуваарийг зохицуулахдаа ТЕЗ-аар дамжуулан Сангийн Сайдын шийдвэрийн дагуу төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах замаар зохицуулах, баталсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах тухай албан шаардлага хүргүүлэв.

3. Багаж, техникийн зардлын төсвөөс 16.0 сая төгрөгөөр тээврийн хэрэгсэл худалдан авч, урсгал зардлаас хөрөнгө бэлтгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хууль 16 дугаар зүйлийн 16.5.5 "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралтаар баталсан "Төсвийн зардлын эдийн засгийн ангилалд ашиглах заавар"-т "210601.Багаж техник хэрэгсэл" заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Баталсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, Төрийн хэмнэлтийн тухай болон Төсвийн тухай хуулиудын холбогдох заалтыг хэрэгжүүлж ажиллах тухай албан шаардлага өгөв.

5.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Бараа материалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Импортоор орж ирсэн бараа материалын гаалийн татвар, хураамж, нэмэгдсэн өртгийн албан татварт төлсөн 79.7 сая төгрөг, шилжин ирсэн автомашинд хийсэн доторлогооны 2.4 сая төгрөгийг бараа материалын болон үндсэн хөрөнгийн өртөгт шингээж бүртгээгүй шууд зардалд бичиж хаасан байна.

Энэ нь Сангийн сайдын 2006 оны "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар" 388 дугаар тушаалын 4.17. "Бараа материалыг олж бэлтгэхэд өртөг бүрдэх зарчмыг үндэслэн тодорхойлсон анхны өртгөөр бүртгэнэ. Бараа материалын өртөг нь худалдан авалтын өртөг, хувиргалтын зардал болон одоогийн байршил ба нөхцөлд бараа материалыг холбогдож гарсан бүх зардал орно.", 4.31 "хөрөнгө гэж хүлээн зөвшөөрөхөөр бэлтгэж буй үндсэн хөрөнгийн зүйлийг эхлээд өртгөөр нь үнэлэх ёстой. Үндсэн хөрөнгийн анхны өртөг нь худалдан авсан үнэ, тээврийн ба ачиж буулгах зардал, бэлтгэх, суурилуулах, тохируулахтай холбогдон гарсан зардал, бүх төрлийн татвар, хураамж зэргээс бүрдэнэ" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Бараа материал, үндсэн хөрөнгийг худалдан авах, суурилуулахтай холбоотой гарсан зардлыг тухайн бараа материал, хөрөнгийн өртөгт үнэн зөв тооцон бүртгэж байх, холбогдох хууль, журам, зааврыг мөрдөж ажиллах.

2. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн шинжтэй 5.8 сая төгрөгийн хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэж, тайлагнасан.

Энэ нь Сангийн сайдын 2006 оны "Төсөвт байгууллагад мөрдөх санхүүгийн тайлан бэлтгэх заавар" 388 дугаар тушаалын 3 дугаар хавсралт.4.78 "Үндсэн хөрөнгө гэдэг нь дараах биет хөрөнгө", б/ "Нэгээс дээш тайлангийн хугацааны туршид ашиглагдахаар хүлээгдэж байгаа хөрөнгө юм" гэсэнтэй тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Үндсэн хөрөнгийг үнэн зөв ангилж бүртгэн, үнэ цэнийг нь бууруулахгүй байх, хөрөнгөнд бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах, дээрх нэр бүхий хөрөнгүүдийг үндсэн хөрөнгийн холбогдох данснуудад шилжүүлэн бүртгэх.

3. Нягтлан бодох бүртгэлийн баримт бичгийн талаар

Илрүүлэлт:

Цаг уур, орчны шинжилгээний салбарт мөрдөх 2020 онд боловсруулсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт холбогдох хууль тогтоомжийн өөрчлөлтийг тусган шинэчлээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйл. 18.3. "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын үйл ажиллагааны онцлог, чиг үүрэгт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн баримт бичигт холбогдох хууль эрх зүйн өөрчлөлтийг тусган шинэчлэх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитын нэр	Нийт алдаа		Мэдээлэл орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Зөвлөмж	
Сүхбаатар аймгийн УЦУОШТ	4	2,480.0			4	2,480.0	4	2,480.0				
	0	-			0	-			2	2,940.0	2	2,940.0
	5	842.9			5	842.9	5	842.9				
Орхон аймгийн УЦУОШТ	1	6,534.9			1	6,534.9	1	6,534.9				
Баянхонгор аймгийн УЦУОШТ	1	20,000.0			1	20,000.0	1	20,000.0				
	1	169.2			1	169.2	1	169.2				
	2	580.0	1	290.0	1	290.0	1	290.0				
Завхан аймгийн УЦУОШТ	1	156.6			1	156.6	1	156.6				
Дорноговь аймгийн УЦУОШТ	1	101,319.8			1	101,319.8	1	101,319.8				
	1	10,180.8			1	10,180.8	1	10,180.8				
Дорнод аймгийн УЦУОШТ	1	5,270.6			1	5,270.6	1	5,270.6				
	1	14,422.9			1	14,422.9	1	14,422.9				
	1	9,551.1			1	9,551.1	1	9,551.1				
Дундговь аймгийн УЦУОШТ	1	1,211.7			1	1,211.7	1	1,211.7				
	1	251.8			1	251.8	1	251.8				
	1	-			1	-	1	-				
	1	97.7			1	97.7	1	97.7				
	1	11,000.0			1	11,000.0	1	11,000.0				
Өмнөговь аймгийн УЦУОШТ	1	296,887.5			1	296,887.5	1	296,887.5				
	1	2,455.0			1	2,455.0	1	2,455.0				
	1	209.8			1	209.8			1	209.8	1	209.8
	1	1,250.0			1	1,250.0			1	1,250.0	1	1,250.0
Өвөрхангай аймгийн УЦУОШТ	1	1,936.0			1	1,936.0	1	1,936.0				
Ховд аймгийн УЦУОШТ	2	65,143.0	1	32,571.5	1	32,571.5	1	32,571.5				
Хэнтий аймгийн УЦУОШТ	1	16,835.6			1	16,835.6	1	16,835.6				
Төв аймгийн УЦУОШТ	2	200.8	1	100.4	1	100.4	1	100.4				
	1	1,387,000.0			1	1,387,000.0	1	1,387,000.0				
	1	863.3			1	863.3	1	863.3				
	1	4,679.0			1	4,679.0	1	4,679.0				
	1	3,078.8			1	3,078.8	1	3,078.8				
	1	962.2			1	962.2	1	962.2				
Говьсүмбэр аймгийн УЦУОШТ	1	63,968.9			1	63,968.9	1	63,968.9				
УЦУОСМХ	1	2,682.8			1	2,682.8	1	2,682.8				
	40	2,030,762.9	3	32,961.9	37	1,997,801.0	37	1,997,801.0	4	4,399.8	4	4,399.8

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Санхүүгийн зөрчлийн дүн		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Архангай аймгийн УЦУОШТ	0	-	0	-	0	-	0	-
2	Баян-Өлгий аймгийн УЦУОШТ	0	-	0	-	0	-	0	-
3	Баянхонгор аймгийн УЦУОШТ	4	10,771.1	2	3,909.1	1	6,862.0	1	
4	Булган аймгийн УЦУОШТ	1	-					1	
5	Говь-Алтай аймгийн УЦУОШТ	2	1,556.0	1	1,000.0	1	556.0		
6	Дорноговь аймгийн УЦУОШТ	4	523.9					4	523.9
7	Дорнод аймгийн УЦУОШТ	4	309,889.6	1	2,635.3	3	307,254.3		
8	Дундговь аймгийн УЦУОШТ	4	1,173.7	1	105.0	3	1,068.7		
9	Завхан аймгийн УЦУОШТ	0	-						
10	Өвөрхангай аймгийн УЦУОШТ	0	-						
11	Өмнөговь аймгийн УЦУОШТ	3	1,459.8					3	1,459.8
12	Сүхбаатар аймгийн УЦУОШТ	4	3,478.9	3	538.9			1	2,940.0
13	Сэлэнгэ аймгийн УЦУОШТ		-						

Цаг уур, орчны шинжилгээний газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

14	Төв аймгийн УЦУОШТ	1	400.0					1	400.0
15	Увс аймгийн УЦУОШТ	0	-	0	-	0	-	0	-
16	Ховд аймгийн УЦУОШТ	2	79,541.9					2	79,541.9
17	Хөвсгөл аймгийн УЦУОШТ	0	-						
18	Хэнтий аймгийн УЦУОШТ	0	-						
19	Дархан-Уул аймгийн УЦУОШТ	1	478.7					1	478.7
20	Орхон аймгийн УЦУОШТ	3	4,671.7	1	381.7			2	4,290.0
21	Говь-Сүмбэр аймгийн УЦУОШТ	1	-					1	-
22	Улаанбаатар аймгийн УЦУОШТ	0	-						
23	УЦУОСМХүрээлэн	1	-					1	
24	БОХЗТЛ	1	6,584.6	1	6,584.6				
25	Нислэгийн цаг уур	0	-						
26	ЦУОШГ аппарат	4	87,924.5	0	-	2		3	87,924.5
	Дүн	41	508,454.4	10	15,154.6	10	315,741.0	21	177,558.8

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт зөрчил		Зөвлөмж		Төлбөрийн акт		Албан шаардлага	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1								
1	Архангай аймгийн УЦУОШТ	-	-						
2	Баян-Өлгий аймгийн УЦУОШТ	-	-						
3	Баянхонгор аймгийн УЦУОШТ	2	251.8			1	251.8	1	
4	Булган аймгийн УЦУОШТ	1	-	1					
5	Говь-Алтай аймгийн УЦУОШТ	2	-	2					
6	Дорноговь аймгийн УЦУОШТ	2	-	1				1	
7	Дорнод аймгийн УЦУОШТ	-	-						
8	Дундговь аймгийн УЦУОШТ	1	-	1					
9	Завхан аймгийн УЦУОШТ	-	-						
10	Өвөрхангай аймгийн УЦУОШТ	-	-						
11	Өмнөговь аймгийн УЦУОШТ	1	19,631.8	1	19,631.8				
12	Сүхбаатар аймгийн УЦУОШТ	1	-	1					
13	Сэлэнгэ аймгийн УЦУОШТ	1	-	1					
14	Төв аймгийн УЦУОШТ	-	-						
15	Увс аймгийн УЦУОШТ	-	-						
16	Ховд аймгийн УЦУОШТ	-	-						
17	Хөвсгөл аймгийн УЦУОШТ	1	196,622.2	1	196,622.2				
18	Хэнтий аймгийн УЦУОШТ	-	-						
19	Дархан-Уул аймгийн УЦУОШТ	1	-	1					
20	Орхон аймгийн УЦУОШТ	-	-						
21	Говь-Сүмбэр аймгийн УЦУОШТ	3	8,934.1	1				2	8,934.1
22	Улаанбаатар аймгийн УЦУОШТ	-	-						
23	УЦУОСМХүрээлэн	-	-						
24	БОХЗТЛ	1	-	1					
25	Нислэгийн цаг уур	-	-						
26	ЦУОШГ аппарат	2	7,749.5	1	7,749.5			1	
	Дүн	19	233,189.4	13	224,003.5	1	251.8	5	8,934.1



37

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 03 дугаар сарын 24

№ 837/00160459

Улаанбаатар хот

С.Энхтүвшин-2023/02/НА-СТД-ТТЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Цаг уур, орчны шинжилгээний газар 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Худалдан авах ажиллагааг харьцуулалтын аргаар 4 удаа зохион байгуулахдаа шалгаруулалт амжилтгүй болсон шалтгааныг судалж, тогтоогоогүй, оролцогчийн ирүүлсэн саналд барааны гарал үүсэл, өртгийн тооцоо байгаагүй, техникийн тодорхойлолт, тавигдах шаардлагыг өөрчлөхөд бараа материалын тоо хэмжээ, хэмжих нэгжийг харьцуулан тооцолгүй шууд гэрээ байгуулж худалдан авалт хийсэн. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль. 30 дугаар зүйлийн 30.4. Бүх тендерээс татгалзсан тохиолдолд захиалагч дараахь шийдвэрийн аль нэгийг гаргана: 30.4.1.тендер шалгаруулалт амжилтгүй болсон шалтгааныг судалж, тендерийн баримт бичгийн агуулгад шаардлагатай өөрчлөлт оруулж нээлттэй тендер шалгаруулалт явуулах; гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.9-т "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулах, хэрэгжилтийг хангаж ажиллах, дээрх зөрчлийг арилгаж, албан шаардлагын биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
3. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цаг уур, орчны шинжилгээний газрын дарга С.Энхтүвшин, ахлах нягтлан бодогч Д.Отгонбаяр нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Г.ГҮНЖИДМАА
Б.НАРАНГЭРЭЛ

0001781768



836

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 03 дугаар сарын 24 № 836/АД01604159
С.Н.Т. 2023/08/Н.А-СТА-ТТЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Цаг уур, орчны шинжилгээний газрын 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Багаж техникийн зардлын төсвөөс 16,000,000.0 (арван зургаан сая) төгрөгийн тээврийн хэрэгсэл худалдан авч, урсгал зардлаас хөрөнгө бэлтгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хууль 16 дугаар зүйлийн 16.5.5.Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралтаар баталсан "Төсвийн зардлын эдийн засгийн ангилалд ашиглах заавар"-т "210601.Багаж техник хэрэгсэл" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийг зардлын эдийн засгийн ангиллын дагуу зарцуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх, албан шаардлагын биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цаг уур, орчны шинжилгээний газрын дарга С.Энхтүвшин, ахлах нягтлан бодогч Д.Отгонбаяр нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Г.ГҮНЖИДМАА
Б.НАРАНГЭРЭЛ





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 03 дугаар сарын 24

№ 835/А0160458

Улаанбаатар хот

СН/ОГ- 2023/02/НА-СТА-ТТЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Цаг уур, орчны шинжилгээний газрын 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

ЦУОШГ-ын 2022 оны санхүүгийн тайлангийн төсвийн гүйцэтгэлийн тайланд гэрэл цахилгаан, түлш халаалт, багаж техникийн зардалд тооцсон 97,899,464.00 төгрөгийг төсөвт зохицуулалт хийж хуваарилалгүй, Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын 2022 оны А/238 тушаалаар харьяа 17 байгууллагын өр төлбөр барагдуулахаар шилжүүлсэн. Санхүүжилт авсан 14 байгууллага 73,521,322.00 төгрөгийг тухайн зардлын ангиллын зориулалтаар зарцуулаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.6.2.төсвийн захирагч нь төсвийн асуудлаа өөрийн харьяалагдах дээд шатны төсвийн захирагчаар дамжуулан шийдвэрлүүлдэг байх. 42.3.Төсвийн шууд захирагчийн төсөвтөө зохицуулалт хийх асуудлыг дараах байдлаар шийдвэрлэнэ: 42.3.2.төсвийн төвлөрүүлэн захирагч нь саналаа харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх; 42.7.Төсөвт зохицуулалт хийхдээ хөрөнгийн болон урсгал зардлыг хооронд нь шилжүүлэх, төсөвт тусгагдаагүй шинэ хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглоно.Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл" гэж заасныг үндэслэн

ШААРДАХ нь:

1. Төсвийн хуваарьт зохицуулалт хийлгэх саналыг дээд шатны төсөв захирагчаар дамжуулан шийдвэрлүүлж байх, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах албан шаардлагын биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цаг уур, орчны шинжилгээний газрын дарга С.Энхтүвшин, ахлах нягтлан бодогч Д.Отгонбаяр нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭГГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Г.ГҮНЖИДМАА
Б.НАРАНГЭРЭЛ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2023 оны 03 дугаар сарын 24

№ 834/А0160459

Улаанбаатар хот

СНМГ-2023/02/НА-СТА-ТТЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Цаг уур, орчны шинжилгээний газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналт сул байгаагаас харьяа байгууллагуудын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар нийт 508,454,400.00 төгрөгийн зөрчил илэрч, 15,154,600.00 төгрөгийн 10 төлбөрийн акт тогтоож, 315,741,000.00 төгрөгийн 10 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 177,558,800.00 төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 20 зөвлөмж өгсөн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-т "Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 15.4.1-т "төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг бодитой тодорхойлох", 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах" 35 дугаар зүйлийн 35.2."Төсвийн байгууллага нь төвлөрүүлсэн төсвийн орлого болон өөрийн үйл ажиллагааны орлогыг Төрийн сангийн нэгдсэн дансанд саадгүй байршуулна" гэж заасантай нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

- 1 Төсвийг зардлын эдийн засгийн ангиллын дагуу зарцуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх, албан шаардлагын биелэлтийг 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
- 2 Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цаг уур, орчны шинжилгээний газрын дарга С.Энхтүвшин, ахлах нягтлан бодогч Д.Отгонбаяр нарт даалгаа.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Г.ГҮНЖИДМАА
Б.НАРАНГЭРЭЛ